ШУТИС-ийн харьяа Өмнөговь аймаг дахь
Технологийн дээд сургуулийн захирлын
2024 оны 01 дугаар сарын 03-ны өдрийн
Б/04 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

# АЖЛЫН БАЙР /АЛБАН ТУШААЛ/-ЫН ТОДОРХОЙЛОЛТ

## I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

**Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:**

☒ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо: Боловсролын ерөнхий хууль /2023 оны 7 дугаар сарын 07-ны өдөр/, Дээд боловсролын тухай хуулийн /2023 оны 7 дугаар сарын 7-ны өдөр/

Дагаж мөрдөх огноо: 2024 оны 01 дүгээр сарын 03-ний өдөр

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо: 2024 оны 01 дугаар сарын 03-ны өдөр

**Байгууллагын нэр:** Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургууль /ӨмТДС/

**Нэгжийн нэр:** Сургалтын алба

**Албан тушаалын нэр:** Ахлах багш

**Албан тушаалын ангилал, зэрэглэл:** ТДС-2-2

**Ажлын цаг:** Ажлын өдөр 8 цаг

**Ажлын байрны албан ёсны байршил:** Өмнөговь, Даланзадгад, Далангийн 3-р баг, Багш хөгжлийн ордон

**Хөдөлмөрийн нөхцөл:** Хэвийн

**Онцгой нөхцөл:** Хамаарахгүй

ШУТИС-ийн харьяа Өмнөговь аймаг дахь
Технологийн дээд сургуулийн захирлын
2024 оны 01 дугаар сарын 03-ны өдрийн
Б/04 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

## II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

**<u>Албан тушаалын зорилго:</u>**

ШУТИС-ийн харьяа Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн эрхэм зорилго, стратегийн зорилттой нийцүүлэн салбар, тэнхимээс шинжлэх ухааны тодорхой чиглэлээр явуулах сургалт, судалгааны ажлыг зохион байгуулахад оршино.

**<u>Албан тушаалын зорилт:</u>**

1. Тодорхой мэргэжлээр бакалавр бэлтгэх сургалтад оролцож, суралцагчдад мэдлэг чадвар дадлага эзэмшүүлэх
2. Е-сургалтын болон эрдэм шинжилгээ судалгааны ажилд оролцох
3. Ном сурах бичиг гарын авлага бичиж, боловсруулах
4. Суралцагчдад онол арга зүйн зөвлөгөө өгч, тэднийг судалгааны ажилд идэвхтэй оролцуулах

| **Зорилт** | **Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг** | **Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт** | **Хариуцлага, оролцооны хэлбэр** Туслах-**Т**, Хариуцан гүйцэтгэх-**Г** Хянах–**Х** Шийдвэрлэх–**Ш** |
|---|---|---|---|
| 1 дүгээр зорилтын хүрээнд | 1. Салбар тэнхимээс хуваарилсан хичээлийн стандарт, агуулга сургалтын төлөвлөгөөг боловсруулан, тогтоосон хуваарийн дагуу лекц унших, семинар, лаборатори дадлагын хичээлийг удирдах<br>2. Салбар, тэнхимийн үндсэн сурах бичиг боловсруулах ажилд оролцох<br>3. Салбар, тэнхимийн хариуцан заадаг хичээлүүдийн стандарт боловсруулах файл бүрдүүлэх | • Хичээлийн хөтөлбөр, стандарт, агуулга, сургалтын төлөвлөгөөг шинжлэх ухааны үндэстэй, дэлхийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн хөгжүүлсэн, шинэчлэн батлуулсан байх, файл бүрдүүлсэн байх<br>• Тогтоосон хуваарийн дагуу хичээлийг удирдан зохион байгуулсан | Т,Г,Х |

| | | | |
|---|---|---|---|
| | 4. Туршилт судалгааны болон лабораторийн төхөөрөмжийг шинэчлэх, туршилтын ажилд биечлэн оролцох<br>5. Мэргэшүүлэх, урт, богино хугацааны сургалтад хичээл заах<br>6. Оюутны мэдлэгийг шалган дүгнэх, судалгаа хийх<br>7. Хөтөлберийн магадлан итгэмжлэл, түүнийг сунгах ажиллагаанд биечлэн Салбар, тэнхимээс зааж буй хичээлүүдээр | • Залуу багш нарын сургалт, эрдэм шинжилгээ судалгааны ажлын дадал, арга зүйд зөвлөгөө өгч ажилласан<br>• Туршилт судалгааны болон даборspecialторийн төхөөрөмжийг шинэчилж, оролцсон байх<br>• Оюутан суралцагчдад сурах арга зүйн зөвлөгөө өгч, зөвлөх багшийн үүргийг чанд биелүүлж ажиллана. | |
| 2 дугаар зорилтын хүрээнд | 1. Е-хичээл бэлтгэхэд оролцох, түүнтэй холбоотой материал боловсруулах<br>2. Гадаад хэл дээр хичээл заах<br>3. Багшийн веб ашиглалт, хичээлийн стандартуудыг удирдлагын мэдээллийн системд оруул хэвших<br>4. Сургалт, үйлдвэрлэлийн холбоог бэхжүүлэх, судалгааны ажлын үр дүнгээр эрдэм шинжилгээний хурал, үзэсгэлэн зохион байгуулахад оролцох<br>5. Төгсөлтийн ажлын сэдвийг бодит объект сонгон, оролцох | • Салбар, тэнхимээс хийх Е-хичээл бэлтгэх ажилд биечлэн оролцсон байх<br>• Мэргэжлийн гадаад хэл дээрх үг хэллэгийг судлан оюутнуудад заасан байх<br>• Гэрээт эрдэм шинжилгээ, суурь судалгааны ажилд оролцсон байх<br>• Эрдэм шинжилгээний хурал, үзэсгэлэн, уралдаан, олимпиад зохион байгуулахад оролцсон байх | Т, Г, Х |
| 3 дугаар зорилтын хүрээнд | 1. Лабораторийн заавар гарын авлага, лабораторийн ажлыг шинээр хийх, тавих ажлыг гардан гүйцэтгэх | • Сурах бичиг гарын авлага бичихэд оролцсон байна.<br>• Сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлэх | Т, Г, Х, Ш |

| | | | |
|---|---|---|---|
| | | ажлыг гүйцэтгэнэ. | |
| 4 дүгээр зорилтын хүрээнд | 1. Оюутны дипломын ажил удирдах, төгсөлтийн шалгалт авах<br>2. Зөвлөх багшаар ажиллах<br>3. Нэгдсэн семинарыг төгсөх оюутнуудад зориулж зохион байгуулахад оролцох<br>4. Сургууль төгсөгч, ажил олгогчийн гурвалсан холбоог батжуулах | • Оюутны дипломын ажил удирдаж, зөвлөж ажилласан байна<br>• Төгсөгчдөд зориулан семинар зохион байгуулсан байна.<br>• Ажил олгогч, төгсөгчтэй гурвансан холбоо бий болгож, ажлын байранд зуучлаж ажилласан байна | Т, Г, Х, Ш |
| Ажлын байрны зорилгын хүрээнд | 1. Сургуулийн удирдлага, салбар тэнхимийн эрхлэгчээс өгсөн үүрэг, даалгаврыг хугацаанд нь чанартай биелүүлэх<br>2. Багийн чадварлаг, эвсэг хамт олон бүрдүүлэхэд өөрийн хувь нэмрийг оруулах | • Өгсөн үүрэг даалгаврын цаг тухай бүрт нь чанартай биелүүлсэн байна.<br>• Байгууллагын хөгжилд өөрийн хувь нэмрийг оруулсан байна. | Т, Г |

## III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

| | |
|---|---|
| **Боловсрол** | Магистр ба түүнээс дээш зэрэгтэй<br>Эсвэл гадаадын нэр хүндтэй их, дээд сургуульд магистр, докторын зэрэг хамгаалсан |
| **Мэргэжил** | Салбар, тэнхимээс бэлтгэн гаргадаг аль нэг мэргэжлээр суурь дээд боловсрол эзэмшсэн магистр зэрэг хамгаалсан |
| **Мэргэшил** | Шинжлэх ухааны тодорхой чиглэлээр мэргэшсэн |
| **Туршлага** | Багшаар10-аас доошгүй жил ажилласан. |

ШУТИС-ийн харьяа Өмнөговь аймаг дахь
Технологийн дээд сургуулийн захирлын
2024 оны 01 дугаар сарын 03-ны өдрийн
Б/04 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

| | | |
|---|---|---|
| ***Ур чадвар*** | Дүн шинжилгээ хийх | - Сургалт, судалгааны арга зүй, багшлах арга барил эзэмшсэн байх<br>- 1-с доошгүй гадаад хэл эзэмшсэн байх |
| | Асуудал шийдвэрлэх | Хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулах, бүтээлч санаачлагатай ажиллах, байгууллагын ёс зүйн хэм хэмжээг сахих, харилцааны соёлыг эрхэмлэх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид шударга байх, байгууллага, хувь хүний нууцыг хадгалах |
| | Багаар ажиллах | Мэдлэг туршлага, ур чадвараа бусадтай хуваацах, хамтран ажиллах, хамт олны эерэг нөлөөтэй уур амьсгалыг дэмждэг байх |
| | Бусад | Гадаад хэлний зохих түвшний мэдлэгтэй, компьютерын өргөн хэрэглээний программ, мэдээллийн технологийн дэвшилтэд технологи ашиглах чадвартай, интернетийн орчноос хэрэгцээт мэдээллийг хайх боловсруулах хэл бичгийн найруулга, дүрмийн мэдлэгтэй байх |

## IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ:

<table>
<tr><td colspan="2">1. Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалтны нэр:<br>Сургуулийн захирал, Сургалт, чанарын албаны дарга, салбар, /тэнхим/-ын эрхлэгч</td></tr>
<tr><td colspan="2">2. Ажлын байрны харилцах субъект</td></tr>
<tr><td>2.1 Байгууллагын дотор талд байгаа</td><td>2.2 Байгууллагын гадна талд байгаа</td></tr>
<tr><td>ӨмТДСургуулийн захирал,сургалт, чанарын албаны дарга, салбар /тэнхим/-ын эрхлэгч, багш, сургалтын албаны ажилтан, бусад нэгжүүд</td><td>Салбар, тэнхим, судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн, төв, лаборатори бусад алба нэгжүүд</td></tr>
<tr><td>3. Албан тушаал эрхлэгчийн хүлээх хариуцлага</td><td>• Хөдөлмөрийн тухай, Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай хууль, Төрийн албаны тухай болон бусад холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага<br>• Хөдөлмөрийн дотоод журамд заасан хариуцлага<br>• Ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээгээр хүлээх хариуцлага<br>• ӨмТДС-ийн дүрэм, Хөдөлмөрийн дотоод журамд заасан хариуцлага</td></tr>
</table>

ШУТИС-ийн харьяа Өмнөговь аймаг дахь
Технологийн дээд сургуулийн захирлын
2024 оны 01 дугаар сарын 03-ны өдрийн
Б/04 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

## V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ:

| **Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан:** | **Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, баталсан:** |
|---|---|
| **Албан тушаалын нэр:**<br><br>Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн бичиг хэргийн ажилтан<br><br>Т. Золжаргал ........................ Т.Золжаргал<br>/гарын үсэг/<br><br>**20 24. оны 01 дугаар сарын 03 ны өдөр** | **Байгууллагын нэр:**<br>Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургууль<br><br>**Шийдвэрийн огноо, дугаар:**<br>2024.01.03<br><br>**Албан тушаалын нэр:**<br>Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн захирал<br><br>........................ Б.Баяржавхлан<br>/гарын үсэг/<br><br>**20 24. оны 01 дугаар сарын 03 ны өдөр** |

---oOo---